

ДҮҮРГИЙН ЗАСАГ НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛСАН 2024 ОНЫ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ
2024 оны 11 сарын 29 ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ Хан-Уул дүүрэг, Улаанбаатар

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт				Биелэлт	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
		Зарцуулсан мөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/		
							/хувь/
3.1.1 Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хэрэгжилт, үр дүнг журмын дагуу тайлагнах							
3.1.2	Монгол хэлний тухай хууль, холбогдох стандартыг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдүүлэх, мөрийн албан хаагчдад үндэсний бичгийн сургалтыг Хэлний бодлогын үндэсний зөвлөл болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах		Зохион байгуулсан сургалт, албан хаагчдын хамрагдалтын хувь	1-ээс доошгүй сургалтад 3-аас доошгүй албан хаагчийг хамруулсан байна.	Байгууллагын нийт 15 багш, ажилтныг монгол бичгийн анхан, дунд шат болон цахим бичвэрийн 96 цагийн сургалтад хамруулсанаас гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын үйлдвэр, аж ахуй барилгын хэлтэс, 401 дүгээр хаалттай хорих анги-нэгдсэн эмнэлэг, Давтан сургалт, сэргээн заслын төв, 113 дугаар анги, 243 дугаар цэцэрлэг, Хөдөлмөр Халамж Үйлчилгээний хэлтэс, Хүүхэд, Гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс, дүүргийн Засаг даргын Тамгын газар гэсэн 7 байгууллагын 236 төрийн албан хаагч хамрагдсан байна. Сургалтын явцад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын үйлдвэр, аж ахуй барилгын хэлтсийн 65 албан хаагчдын монгол бичгийн сургалтын үр дүнг тайлагнах, монгол бичгийн олон талт хэрэглээний чадвар, багаар ажиллах чадварыг сайжруулах, чиглэлээр "Үндэсний бичиг-бидний бахархал" тэмцээнийг 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгууллаа.	100%	
3.1.3	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх (сургуулийн гадна байгаа хүүхэд болон сургууль завсардсан хүүхэд, залуучуудад боловсрол нөхөн олгох, ажлыг зохион байгуулах);		Боловсролд нөхөн хамрагдсан хүүхдийн тоо, эзлэх хувь	Хүүхэд 82 тоо, эзлэх 100 хувь	2024 оны хагас жилээр боловсрол нөхөн эзэмшихээр бага боловсролд -3, суурь боловсролд -28, бүрэн дунд боловсролд -51, нийт 82 суралцагч суралцаж 5-р ангийг 2, 9-р ангийг 8, 12-р ангийг 25 нийт 35 суралцагч төгссөн бол 2024-2025 оны хичээлийн жилд Боловсрол нөхөн олгох нийт 61 суралцагч бага боловсролд -3, суурь боловсролд -20, бүрэн дунд боловсролд -38 суралцагч суралцаж байна.	100%	

3.1.4	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх (бүх нийтийн соёлын боловсрол арга хэмжээг хэрэгжүүлэх ХЗДХ, ХНХ, БШУ, ЦХХХ, ЭМ, Соёлын сайд, НЗД нарын 2023.12.05-ны өдрийн хамтарсан албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах);		Дэмжиж хамтран ажилласан өв уламжлагчдын тоо, эзлэх хувь	151 өвлөн уламжлагч, 7 хуурч	Дүүрэгт бүртгэлтэй өвлөн уламжлагчдыг таниулах зорилгоор "Урлахуйг өвлөө" гар урлал сонирхогчдын уулзалтыг иргэдээс судалгаа авч нэгтгэн, зохион байгуулсан. Хан-Уул дүүргийн 25 хорооны 84 иргэн оролцсон сургалт, уулзалтад өвлөн уламжлагч хатгамалч, нэхмэлч Д.Янжиндулам, даалин урлаач, нэхмэлч Б.Гэрэлцэцэг нар зочноор оролцож бүтээлүүдээ танилцууллаа. Хүрэлцэн ирсэн бүсгүйчүүд маань өөрсдийн сонирхон бүтээдэг гар урлалын талаар санал туршлагаа солилцсон, мэдлэг бүтээсэн, өв уламжлалаа дээдэлсэн үр өгөөжтэй сайхан уулзалт болсон. Цаасан хайчилбар хийдэг иргэн Н.Батцэцэг, гар нэхмэлч даалин урлаач, Ш.Гэрэлмаа, номын хавчуурга жижиг чимэглэл урлаач Р.Элбэгзаяа нарын бүтээлтэй танилцсан нь онцлог байсан.	100%		
3.1.5	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг ханган, тайлагнан ажиллах			3	Байгууллага дээр "Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг 7 бүлэг 71 зүйлээр батлан мөрдөн ажиллаж байна. 2024 онд тус төвийн Боловсрол нөхөн олгох ангид оюуны бэрхшээлтэй 1, хавсарсан бэрхшээлтэй 2, тулгуур эрхтний бэрхшээлтэй 1 нийт 4 сурагч танхимаар суралцахаас гадна, хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 5 хүүхэд нийт 9 хүүхдийн ахицыг үнэлэн гэрээр сургалтад хамруулан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулж байна. Байгууллагын дотоод журамд "Жендэрийн тэгш байдлыг хангах 9 заалтыг шинэчлэн оруулж, батлууллаа.	100%		
3.1.6	Байгууллагын төсвийн орлого, зарлага, тайлангийн бүх мэдээллийг олон нийтэд ил тод байхаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;		8 багц үйл ажиллагаа	оруулсан мэдээ, мэдээллийн тоогоор	2024 оны 11 дугаар сарын 31-ны байдлаар шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хүрээнд: Shilendans.gov.mn цахим хуудсанд хуулийн хугацаанд байгууллагын мөнгөн хөрөнгийн хөдлөл, санхүүжилт, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, хэтрэл хэмнэлтийн мэдээ тайлан, тушаал шийдвэрүүд, сар, улирал, хагас жилийн мэдээ, тухай бүрийн мэдээ болон нийт 140 мэдээ мэдээллийг цаг тухай бүрд нь шилэн дансанд бүрэн байршуулан ажиллаж байна.	100%		
3.1.7	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;			10	12	2024 оны батлагдсан төсөвт багтаан Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулах, хичээл практик, бараа үйлчилгээний зардлыг үр ашигтай зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай" хуулийг хэрэгжүүлэн байгууллагын цахилгаан дулаан, цэвэр усны хэрэглээг хэмнэж өр авлагагүй ажиллаж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн эцсийн өдрөөр тасалбар болгон төсвийн захирагчид хянуулан дараа сарын 2-ны дотор харилцагч боловсролын хэлтэс болон төрийн сангийн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна	100%	

3.1.8	Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалтын дагуу "Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл", мөн 8.6.22, 8.13, 8.14-т заасан мэдээллүүдийг дүүргийн цахим хуудасд хуульд заасан хугацаанд байршуулах, өөрчлөгдсөн тохиолдолд 8.11-д заасны дагуу 3 хоногийн дотор мэдээллийг шинэчлэх;		4	4	Байгууллагын вэб болон пэйж дээр байгууллагын хаяг байршил, сар бүр зохион байгуулдаг оёдол эсгүүр, үсчин, компьютер, солонгос хэлний сургалтын цагийн хуваарь, бүрдүүлэх материал, боловсрол нөхөн олгох хөтөлбөрт хэрхэн хамрагдах, насан туршийн 5 чиглэлийн сэдэв, сургалтын захиалгыг хэрхэн өгөх зэрэг үйлчилгээний нэр төрлийг байршуулан, улирал тутамд шинэчлэн ажиллаж байна. Байгууллагын вэб сайт болон пэйж хуудсыг QR code-той болгосноор иргэд аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээ мэдээллээ түгээх, сар бүрийн амьжиргааны сургалтад иргэдийг цахимаар бүртгэдэг боллоо. Google forms программаар 2024 онд нийт 656 иргэн хамрагдлаа.	100%	
3.2. Төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд:							
3.2.1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллах;		0	0	2024 онд худалдан авалт хийгдээгүй бөгөөд Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг хуулийн хүрээнд сар бүрийн 2-ны дотор харьяа төрийн сангийн мэргэжилтэнд хүргэн ажиллаж байна.		
3.3. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хүрээнд							
3.3.1	Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирж байгаа өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг сайжруулж, иргэдээс харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг эрх хэмжээнийхээ хүрээнд бүх талаас нь судлан үзэж, шуурхай, хуулийн хугацаанд, үндэслэлтэй хариу өгч, бүрэн барагдуулж шийдвэрлэх		0	0	2024 оны байдлаар манай байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах өргөдөл, гомдол иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирээгүй болно. Төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын талаар байгууллагын ажилчдад 2 удаа сургалт зохион байгуулж, цахим орчинд иргэдэд хэрхэн мэдээлэл өгөх чиглэл өгч ажиллав	100%	
3.3.2	Иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй, шийдвэрлэх явцад ёс зүйн зөрчил гаргасан, тайлан мэдээг дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүлж ажиллаагүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцож, сахилга, хариуцлагыг чангатгах;			10	Иргэд болон багш ажилтнуудаас ирүүлсэн ажилд орох, ажлаас гарахыг хүссэн 10 өргөдлийг бүртгэж, шилжүүлж, зөрчилгүй, шийдвэрлэж ажиллалаа.	100%	
3.3.3	Байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг мэргэжлийн байгууллагаар улирал бүр хийлгүүлж, дүнг үндэслэн цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.	сар бүр авах		250-иас доошгүй иргэнийг хамруулсан байна.	Сар бүр сургалтад хамрагдсан иргэдээс хэрэгцээний болон сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг тооцон ажиллаж байна. 2024 онд 743 иргэн хэрэгцээний судалгаанд, 1439 иргэн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдлаа.	100%	
3.4. Хотын хөгжлийн индексийн хүрээнд							

3.4.1	Хотын хөгжлийн индексийн өөрийн байгууллагын хамаарах үзүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, хүрсэн үр дүнг 2024 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцох ажлыг зохион байгуулах		Боловсролд нөхөн хамрагдсан ба бичиг үсэг тайлагдсан иргэдийн тоо	Хүүхэд тоо 82-оос дээш бичиг үсгийн тайлагдалт 8	Хотын хөгжлийн индексийн байгууллагын чиг үүрэгт хамаарах боловсролын чиглэлээр жил бүрийн 5 дугаар сард хороодоос бичиг үсэггүй болон сургууль завсардагчдын судалгааг авч, анхан шатны сургалтад 9 иргэн хамрагдлаа. Боловсрол нөхөн олгох хөтөлбөрт 2024 оны 6 дугаар сард 82 суралцагч төгссөн ба одоогоор 61 суралцагч суралцаж байна.	100%		
3.4.2	Хотын хөгжлийн индекс болон тухайн байгууллагын суурь мэдээллийг орон зайд суурилсан нийслэлийн дундын мэдээллийн санд тухай бүр оруулж ажиллах.		Тухай бүр байршуулсан мэдээлэл, хэрэгжилтийн хувь	Үзүүлэлтэд заасан мэдээллийг тухай бүр дундын мэдээллийн санд оруулна	Байгууллагын чиг үүргийн дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааны мэдээ, мэдээллээ дүүргийн албан ёсны www.khanuul.mn вэб хуудаст 2 мэдээ, Хан-Уул Эко дүүрэг цахим бүлэг болон Насан туршийн суралцахуйн багш нарын нэгдсэн бүлэгт нийт 25 мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт нийтлэн байршуулж иргэдийг үнэн зөв, шуурхай мэдээллээр ханган ажилласан. Байгууллагын цахим хуудсаар дамжуулан сургалт, нөлөөллийн ажилтай холбоотой 147 мэдээ, 10 удаагийн сургалтын зар, 10 удаа ажлын байрны зарыг оруулан үйлчилгээгээ үе шаттайгаар цахимжуулж байна. Байгууллагын цахим хуудсанд 2024 онд байгууллагын пэйжид 2014 дагагч нэмэгдэж, 540,119 хандалт авч үйлчилгээгээ үе шаттайгаар цахимжуулж байна	100%		
3.5. Хот нийтийн аж ахуйн хүрээнд								
3.5.1	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж (Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол) өмнө жил тарьсан модоо арчилж тордох, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд мод тарьж, ургуулах ажилд идэвхтэй оролцох			28	48	"Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Айцын аманд 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр багш, албан хаагчид батлагдсан хуваарийн дагуу 2022, 2023 онд тарьсан бут сөөгийн усалгаа, арчилгаа хийж, шинээр 28 ширхэг хуайс мод тарьж ажиллалаа. Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан 2024 оны 10 дугаар сард 20 шар хуайсыг нэмж, нийт 48 мод тариллаа.	100%	
3.5.2	Нийслэл, дүүргээс зохион байгуулдаг хот, нийтийн аж ахуйн ажилд идэвхтэй оролцох, орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам, явган зам талбайг засварлах, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийх, гадна тохижилт, хайс хашлага, хаягийн байгууламжийг стандартад нийцүүлэх;			10	10	Хан-Уул дүүргийн Засаг даргын захирамжаар 2024 оны 01 сарын 13-нд "Халтиргаа, гулгаанаас сэргийлье" их цэвэрлэгээ, 03 дугаар сарын 23-нд Туул голын 7 дугаар байршлын хог цэвэрлэгээ, 04 сарын 05-ны өдрүүдэд байгууллагын өрөө тасалгаа, их цэвэрлэгээ, 05 дугаар сарын 13-ны өдрийн "ХОТОО УГААЯ" бүх нийтийн их цэвэрлэгээ, "Шарилжгүй УБ", Дүүргийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын хүрээндхөг цэвэрлэх аянд нийт 10 удаа байгууллагаараа оролцсон	100%	
3.7. Бусад								
3.7.1	Энэхүү гэрээний 5.2, 5.3-т заасан хугацаанд гэрээний хэрэгжилтийн тайланг ирүүлэх; 5.1. Гэрээний биелэлтийн хагас жилийн тайланг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор, бүтэн жилийн тайланг 2024 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор дүүргийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ. 5.2. Санхүүгийн хагас жилийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацааны дотор батлагдсан заавар, журмын дагуу гаргаж, хөтөлбөрийн үр дүнгийн тайлангийн хамт төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ			4	4	5.1. Дүүргийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээ болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг хагас бүтэн жилээр хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа. 5.2. Санхүүгийн 2024 оны хагас жилийн тайланг төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан журмын дагуу гаргаж 2024 оны 07-р сарын 5-нд баталгаажуулан Хан-Уул дүүргийн төрийн сангийн хэлтэст, Хан-Уул дүүргийн боловсролын хэлтсийн санхүүгийн мэргэжилтэнд хянуулж Э-тайланг баталгаажуулж ажилласан.	100%	

3.7.2	Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах;		50	60	Байгууллагын цахим хуудсаар дамжуулан сургалт, нөлөөллийн ажилтай холбоотой 147 мэдээ, 10 удаагийн сургалтын зар, 10 удаа ажлын байрны зарыг оруулан үйлчилгээгээ үе шаттайгаар цахимжуулж байна. Байгууллагын цахим хуудсанд 2024 онд байгууллагын пэйжид 2014 дагагч нэмэгдэж, 540,119 хандалт авч үйлчилгээгээ үе шаттайгаар цахимжуулж байна.Сургалт болон Боловсрол нөхөн олгох ангид орох ,гаргах өргөдөл, хүсэлтийг ажлын 3 хоногийн дотор шийдвэрлэдэг.Хүнд суртал, авлига үүсгэхгүй тул анхаарч ажиллаж байна.	100%	
3.7.3	Төрийн албаны хүний нөөцийг чадавжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгох;		сургалтад хамрагдсан тоо	150 цагийн сургалтад хамрагдах	2024 оны жилийн эцсийн байдлаар багш ажилтнууд үндэсний хэмжээний 10 удаагийн 146 цагийн сургалт, орон нутгийн түвшинд 24 удаагийн 117 цагийн сургалт, ажлын байран дээр 70 удаагийн 245 цагийн нийт 508 цагийн сургалтыг хувь хүний хөгжилд зориулсан байна.Багш, ажилтнуудын ажлыг сар бүр үнэлэхдээ ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг жилд 2 удаа бусад ажилтнуудаас санал асуулга авч үнэлгээнд оруулж ирлээ.	100%	
3.7.4	Төрийн цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний шат дамжлагыг багасгах, чанар, хүртээмжийг сайжруулах		цаасан суурьтай бичгийн тоо багассан байх	цахимаар ирсэн, явсан бичгийн тоо	Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу ирсэн бичиг 197, явсан 58 бичгийг бүртгэж шийдвэрлэн, хяналт тавих, албан хэрэг хөтлөлтийн шатанд хадгалан ашиглаж, хөтлөх нэрийн жагсаалтын дагуу албан хэрэг бүрдүүлэх, ERP системд албан бичиг боловсруулах зэрэг ажлыг хийж байна.	100%	
3.7.5	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх;		6-7 хуулийг мөрдөх	хуулийн заалтыг дагаж мөрдсөн эсэх	Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Архивын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Монгол хэлний тухай хууль,Цахим гарын үсгийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар, Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам болон холбогдох эрх зүйн актуудыг дагаж мөрдөж ажиллаж байна.	100%	
3.7.6	Дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд тухай бүр оролцож, өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж тухай бүр тайлагнах;		20	20	Дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд тогтмол оролцож өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь чанартай гүйцэтгэж тайлагнаж ажилласан.Мөн 7 хоногийн мэдээг хүргүүлж ажиллав.	100%	
3.7.7	Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ өгсөн ажлын хэсгээс хүргүүлсэн зөвлөмж, дүгнэлтэд тусгасан ажлыг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж хагас, бүтэн жилээр тайлангийн хамт, үр дүнг нь үнэлэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлэх;		1	1	Баримтад цахим хувь үйлдэх, бүх шатны байгууллагаас мэдээлэл лавлагааг онлайн хэлбэрээр авах ашиглуулах нөхцөлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023 оны үйл ажиллагааны явцад үүсэн захирамжлалын:А-тушаал 18 (хавсралт-хуудас) нийт 40 хуудас, Б тушаал 64 нийт 82 хуудас , бүгд 82 тушаал (хавсралт-40 хуудас) нийт 122 хуудас баримтыг Archive Edoc программд оруулан хянуулан ажилласан.	100%	

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ,
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

тамга

Ц.ДУЛАМСҮРЭН

огноо
2024 11 дүгээр сарын 29